



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 23 өдөр


Дугаар A/1359

Улаанбаатар хот


Г Орон тооны бус спортын зөвлөлийн
бүрэлдэхүүн, ажиллах журам
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.“Орон тооны бус спортын зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
- 2.Ажлын төлөвлөгөө, тайлан, төсвийг холбогдох журамд заасны дагуу батлуулж ажиллахыг Спортын зөвлөл (Г.Билэгт)-д үүрэг болгосугай.
- 3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан байгууллагын даргын 2021 оны А/197 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
- 4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Д.Давааням)-т даалгасугай.



172301375



Гадаадын иргэн харьяатын газрын даргын
2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн
13-дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Орон тооны бус спортын зөвлөлийн бүрэлдэхүүн

Дарга:

Г.Билэгт Иргэний харьяаллын газрын дарга

Гишүүд:

Г.Хосбаатар	Зөрчил шалган шийдвэрлэх газрын хяналтын улсын байцаагч
Ж.Золжаргал	Зөрчил шалган шийдвэрлэх газрын хяналтын улсын байцаагч
Л.Жаргалмаа	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн
Н.Болорцэцэг	Санхүүгийн хэлтсийн ахлах нягтлан бодогч
О.Шинэнэмэх	Захиргаа, удирдлагын газрын бичээч
Б.Ганчимэг	Хангарт, үйлчилгээний хэлтсийн үйлчлэгч

Нарийн бичгийн дарга:

Б.Батцоож Хангарт үйлчилгээний хэлтсийн биеийн тамирын
арга зүйч

Гадаадын иргэн, харьятын газрын даргын
2023 оны 10 дугаар сарын 23.-ны өдрийн
139 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Орон тооны бус спортын зөвлөлийн ажиллах журам

Нэг. Зорилго

1.1. Энэ журмын зорилго нь орон тооны бус спортын зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх-еөс байгууллагын албан хаагчдын дунд биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажлыг тогтмол зохион байгуулах, бие бялдрын боловсрол, соёлыг дээшлүүлэн, хөдөлгөөний хомсдоос урьдчилан сэргийлэх, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээнд идэвхтэй оролцуулах, амьдралын зөв хэв маягийг төлөвшүүлэх, эрүүл чийрэг, спортлог хамт олныг бүрдүүлэхэд оршино.

Хоёр. Зөвлөлийн эрх, үүрэг:

2.1. Зөвлөл нь дараах эрхтэй:

2.1.1 Хамт олны дунд зохион байгуулах биеийн тамирын арга хэмжээны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор байгууллагын даргаар батлуулах;

2.1.2 Хамт олны дунд зохион байгуулах арга хэмжээны заавар, сургалт, арга зүйн чиглэлийг боловсруулах, батлуулах, сурталчлах, хэрэгжилтийг хангах;

2.1.3 Тэмцээн, уралдаанд оролцогчдоос сонгон шалгаруулж аливаа тэмцээн, уралдаанд оролцох багийг бүрдүүлэх;

2.1.4 Байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээнд тогтмол идэвхтэй оролцдог газар, хэлтэс, албан хаагчдыг байгууллагын хэмжээнд алдаршуулах, урамшуулах, жилийн эцсийн ажлын үр дүнг үнэлэх үзүүлэлтэд харгалzan дүгнүүлэх талаар үнэлгээний багт санал оруулах.

2.2. Зөвлөл нь дараах үүрэгтэй:

2.2.1 Биеийн тамирын чийрэгжүүлэлт, спортын төрөл бүрийн арга хэмжээ, тэмцээн уралдааныг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, холбогдох байгууллага, арга зүйч, мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг тооцох;

2.2.2 Байгууллагын хамт олны дунд биеийн тамир, спортыг хөгжүүлэх, бие бялдрын чийрэгжүүлэлтийг сайжруулах чиглэлээр бусад байгууллагын спортын зөвлөлөөс туршлага судлах, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

2.2.3 Биеийн тамир, спортын салбарын төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд хамт олныг идэвхтэй оролцуулах;

2.2.4 Байгууллага дээрээ биеийн тамир, чийрэгжүүлэлт, спортын чиглэлээр сургалт зохион байгуулах, холбогдох байгууллагаас мэргэжил, арга зүйн туслалцаа авч хамтран ажиллах;

2.2.5 Байгууллагын албан хаагчдыг 7 хоногт нэгээс доошгүй удаа спорт зааланд хамруулах ажлыг зохион байгуулж, холбогдох байгууллагатай гэрээ хийж, хэрэгжүүлэх;

Гурав. Байгууллага, хамт олны эрх, үүрэг

3.1. Хамт олон дараах эрхтэй:

3.1.1 Зөвлөлөөс тухайн жилд хамт олны дунд зохион байгуулах арга хэмжээнүүдийн төлөвлөгөөнд санал өгөх;

3.1.2 Зөвлөлөөс зохион байгуулсан арга хэмжээнд тогтмол идэвхтэй оролцох, урамшуулалт авах;

3.2. Хамт олон дараах үүрэгтэй:

3.2.1 Зөвлөлөөс зохион байгуулж буй аливаа арга хэмжээнд идэвх, санаачлагатай оролцох;

3.2.2 Албан ажлын шаардлагаар болон эрүүл мэндийн хувьд хүндэтгэн үзэх шалгааны улмаас тэмцээн, уралдаанд оролцох боломжгүй тохиолдолд урьдчилан мэдэгдэх.

Дөрөв. Төсвийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагнант

4.1. Зөвлөл нь ирэх оны төлөвлөгөө, түүнд шаардагдах төсвийг жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор төлөвлөгөөнд тусган батлуулж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнана.

4.2. Төвлөрсөн төсвийг дараах арга хэмжээнд зарцуулна:

4.2.1 Байгууллага хамт олны дунд зохион байгуулах төрөл бүрийн уралдаан тэмцээн;

4.2.2 Байгууллагын албан хаагчдын гэр бүлийн дунд зохион байгуулах төрөл бүрийн уралдаан тэмцээн;

4.2.3 Байгууллагын албан хаагчдад чиглэсэн спортын сургалт.

4.3. Төсвийг зарцуулах саналыг зөвлөлийн гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн, олонхийн саналаар төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

4.4. Төсвийн зарцуулалтад байгууллагын дарга, санхүүгийн хэлтсийн дарга, ахлах нягтлан бодогч хяналт тавьж ажиллана.

4.5. Төсвийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.

Тав. Бусад зүйл

5.1. Зөвлөлөөс зохион байгуулах аливаа арга хэмжээ нь байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, байгууллагын төлөвлөгөөтэй уялдана.

5.2. Энэ журмыг зөрчсөн албан хаагчдад холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага ногдуулна.